

Ховд аймаг дах шашны өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага

Ц.Пүрэвсүрэн- Ховд Их Сургууль. Философийн багш, докторант

Өнөөдөр дэлхий дээр маш олон төрлийн шашин шүтлэг байдаг тэдгээрээс дэлхийн шашин гэж тооцогддог Буддын шашин 2545 жил, Христосын шашин 2000 жил, Исламын шашин 1521 жил оршин сургааль номлолоо хөгжүүлж ирсэн байна. Эдгээр шашин бүр өөр өөрийн гэсэн номлол ёс суртахууны дүрэм журамтай байдаг. **(1)**

Шашин шүтлэг нь аливаа ард түмний хийгээд улс үндэстний соёл иргэншлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсоор ирсэн түүхтэй. Ийм учраас шашин нь аливаа үндэсний соёлын бүрэлдэхүүн хэсэг болдог. Сүүлийн жилүүдэд Монгол орны хүн амын шашин шүтлэгийн байдалд эрс өөрчлөлт гарав. Энэ өөрчлөлтийн онцлог нь нэг талаас, шашин шүтлэг сэргэж, шашныг шүтэн бишрэгч, талархан дэмжигчид, сонирхогчид идэвхижин, тэдний нийгэмд эзлэх хувийн жин нэмэгдэж байгаагаар, нөгөө талаас шүтлэг бишрэлийн шинж чанарт өөрчлөлт орж, монголчууд шашны нэгэн төрөл байдлаас гарч, олон шашин зэрэгцэн орших болсонд оршино.

Монголын нийгмийн шашны амьдралд гарсан нөхцөл байдал, үйл явцын цаашдын өрнөл, хандлага нь уламжлалт ба уламжлалт бус шашны харилцаанаас ихээхэн хамааралтай гэж хэлж болно. Уламжлалт шашин гэдэг нь аль нэг угсаатан, үндэстэн, улс оронд түүхийн нэлээд урт удаан хугацаанд оршин тогтнож, үзэл номлол, үйлдэл шүтлэг нь үндэсний уламжлал, ёс заншилд нэвчин шингэж, ахуй амьдралд нь идээшин дасаж, аажмаар тухайн улс үндэстний болон ард түмний соёлын салшгүй содон шинж, үндсэн элемент болон төлөвшиж, улмаар тэр соёлыг дараа үеийнхэнд дамжуулан хэвшүүлж байдаг тийм шашныг хэлнэ. **(4. тал.76-77)**

Цаг хугацааны хувьд харьцангуй саяхнаас үүссэн үзэл номлол, үйлдэл шүтлэг нь үндэсний уламжлалтай төдий л холбоогүй, ихэвчлэн гаднаас орж ирж байгаа, эсвэл тухайн нийгмийн огцом өөрчлөлт буюу хямралт байдлын үр дагавар болон гарч ирж байгаа, эхэн үедээ нийгмийн зүгээс олонхийн дэмжлэг, хүндэтгэлийг төдий л хүлээгээгүй тийм шүтлэгийн хэв маягийг уламжлалт бус шашин гэнэ. **(4. мөн тэнд)**

Монгол дах шашныг дээрх ангиллаар авч үзвэл, уламжлалт шашин гэдэгт юуны өмнө хэдэн зууны түүхтэй буддын шашин, эртний язгуурын уламжлалтай бөөгийн шашныг нэрлэж болно. Мөн манай орны хүн амын тодорхой хэсэг буюу угсаатны нэгэн нийтлэг болох казахын уламжлалт шүтлэг болсон ислам шашин байна.

Уламжлалт бус шашин гэдэгт 1990-ээд оноос хойшхи хугацаанд монголд орж ирсэн шашны урсгалууд үндсэндээ хамаарагдана. Тэдгээрийг ерөнхий нийтлэг шинжээр нь нэгтгэвэл доорхи 2 бүлэгт хуваан үзэж болох байна. Үүнд: 1-рт, христосын чиглэлийн, өрнө дахины улбаатай шашнууд, 2-рт, бусад янз бүрийн шашны урсгалууд. Тухайлбал, энд Ананда марга, Бахайн шашин, Язу тарнийн г.м.

Эхний бүлэгт багтах шашнуудыг дотор нь христосын шашны эртний уламжлалтай католикийн болон үнэн алдартны чиглэлийн протестантизмын эхэн үеийн урсгалууд юм. Эдгээр нь манайд харьцангуй цөөн. Нөгөө хэсэг нь нэлээд хожуу үеийн протестантизм буюу “америкжсан” шашин, өөрөөр хэлбэл америкаас ази дорно дахины болон европын орнуудад түгэн тарж, тэндээсээ монголд орж ирж буй шашнууд гэж ангилан үзэж болох байна.

Өнөөдрийн байдлаар Ховд аймгийн хэмжээнд дэлхийн гурван том шашны төлөөлөл болсон уламжлалт бус шашин (америкжсан шашин) болох Есүс Христийн протестант чуулган, Есүс христийн Ховд-Амьд-Үг-Баптист төв, Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм, уламжлалт шашин болох Буддын шашны Түгээмэл амаржуулагч хийд, Тэгчинчойнхорлон хийд, Мусулманы шашны "Казак"-ийн сүм 6 сүм хийд үйл ажиллагаа явуулж байна

Есүс Христийн протестант чуулган нь 2007 оны 7 сарын 19-нд Монгол Улсын Хууль зүйн Яамнаас зөвшөөрөл авч байгуулагдсан бөгөөд аймгийн төвд Авралын зам (Трестийн улаан булан), Мөнхийн дуудлага (Ардчилсан намын байр), Өгөөмөр хайр (Эх орон намын байр), Шинэ амьдрал (Бугат 4-18), Өсөх ирээдүй (Цамбагарав багийн ойн бүсэд), Гэр цуглаан (Станцын орон сууц) гэсэн 6 нэршил бүхий сүм, хөдөө орон нутагт 12 суманд 12 сүм, нийт 18 сүм цуглаан нь Дарви, Мөнхайрхан, Ховд сумуудаас бусад бүх сумуудад шашны номлогчдийг суурин байдлаар ажиллуулж шашны үзэл номлолоо сурталчилж байна. Эдгээр шашны үйл ажиллагааг ерөнхийдөө 7 хүн удирддаг, Библийн сургаалийг номлодог, санхүүжилтийн 10% нь сүсэгтнүүдээс бусад нь төвөөсөө ирдэг, 3.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, ном сурах бичгийн хангалт, хүрэлцээ сайн. Сүсэгтний тоо өдөр ирэх тусам хурдацтай нэмэгдэж байгаа гэсэн үндэслэлээр сүм барих газрын зөвшөөрлийг 2008 оны 3 сарын 6-нд №11101 тоотойр Аймгийн Иргэдийн Хурлын төлөөлөгчдөд гаргасан байх юм.

Ховд -Амьд-Үг-Баптист сүм нь Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын №247 тоот тогтоолоор байгуулагдсан ахлагч, номлогч (пастер), орчуулагч гэсэн 3 үндсэн орон тоотой, Баатархайрхан багийн нутагт Оргил төвийг түрээсэлдэг, Нормоны ном номлодог, протестантаас ялгаатай нь номлолоо амьд үгээр явуулдаг, санхүүжилт болон ахуй хангамжаа Улаанбаатар дах төвөөс болон өргөл авдаг. Итгэгчдээс өргөл авдаггүй. Одоогоор хөдөө орон нутагт салбар үгүй.

Есүс христийн "Хожмын гэгээнтнүүдийн сүм" буюу Нормоны сүм нь Монгол Улсын Хууль зүйн яамны 1994 оны №13 тоот тогтоолоор үйл ажиллагаа явуулах Бүртгэлийн дугаар №9534 гэсэн зөвшөөрлийг авсан. Ховд аймагт үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлгүй. Үйл ажиллагааг 6 номлогч (пастер) удирддаг, санхүүжилт нь төвөөсөө авдаг, материалаг хангамж, ном сурах бичиг хангалттай байдаг. Номлогчид нь Нормоны сургаалийг гадуур явж айлдахын зэрэгцээ ням гариг бүрт цуглаан хийдэг. Англи хэлний анхан болон дунд шатны үнэгүй сургалт, төгөлдөр хуурын сургалт явуулдаг. Одоогоор хөдөө орон нутагт салбар үгүй.

"Түгээмэл амаржуулагч" хийд нь Баруун бүсийн буддын шашны нэг томоохон сүм бөгөөд 1750-иад оны орчим анх шавийг тавьсан боловч Манжийн түрэмгийллийн улмаас үйл хэрэг нь хойшлогдож, 1760-аад оны үед тухайн үеийн дайнаар олзлогдсон ойрад цэргүүдийн хүчээр байгуулах ажил өрнүүлж байхад, өөлдийн гэлэн Дондов гэгч санаачлан Буянт голын баруун эрэгт Ховд хотод ойрхон гурван гэрт үйл ажиллагаа явуулах замаар эхэлсэн байна. Улмаар уг сүмийг Манжийн амбаны Хуувин сайд Яманга Дондов гэлэнтэй багш шавийн харилцаа тогтоож, Манжийн тэнгэрийг тэтгэгч хаанд сүм байгуулах саналаа уламжилсан нь зөвшөөрөгдөж тухайн үед түмэн лан мөнгө зарцуулж бүтээсэн гэдэг. Манжийн тэнгэрийг тэтгэгч (Цян-Лүн) гэгч эзэн хааны зарлигт "улаан нэхрй жил буюу 1766 оны намрын сүүл сараас үйлдүүдэн эхэлж, улаагчин гахай жил буюу 1767 онд үйлдэж төгсөв" хэмээсэн буй. Мөн "Түгээмэл амаржуулагч" нэрт гэж илэрхийлэн бичиг өргөж, гэрэлт хөшөөний бичиг бичээд, чулуунд сийлж, магтаал үг шүлэглэв" хэмээсэн нь манж, хятад, монгол гурван хэлээр бичсэн хувилбар нь Галдангийн "Эрдэнийн эрх"-д хадгалагдан үлдсэн байна.

Уг сүмийн үйл ажиллагаа ХХ зууны монголын нийгэм улс төрийн амьдрал дах хувьсгалт өөрчлөлтийн үр нөлөөгөөр устгагдаж, 1990 оны ардчилсан хувьсгалын үед дахин сэргээн засварласнаар одоо Ховд хотын төвд нүүж ирэн өнөөдөр хамба лам-1, лам-9, ажилчин-3 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр шашин номын үйл хэргийг эрхэлж байна. Үндсэн хөрөнгө 4.9 сая, төвд болон тод үсгээр туурвигдсан бурханы ном судруудаар бүрэн хангагдсан, шарын шашны үзэл номлолыг номлодог, орлогоороо санхүүждэг, ажлын 7 хоногт тогтмол ном хурдаг, сүсэгтнүүдийн хамрах хүрээ сайн.

“Тэгчинчойнхорлин хийд” Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2003 оны 10 сарын 13-ны 194 тоот тогтоолоор зөвшөөрөгдөн үйл ажиллагаа явуулж байна. Буддын шашны улааны урсгалыг баримталдаг, хувийн судар номоор үйлчилгээгээ явуулдаг. Үндсэн хөрөнгө 7.5 сая, лам-6, шавь-3 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг, орлогоороо санхүүждэг, ажлын 7 хоногт тогтмол ном хурдаг, сүсэгтнүүдийн хамрах хүрээ сайн. Буяны ном хурахын зэрэгцээ мэргэ төлөг үздэг.

Казадын сүм нь 2005 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаад сүүлийн 2 жил орчмын хугацаанд үйл ажиллагаа нь бараг бүрэн зогссон. Учир мэдэх хүмүүсээс үйл ажиллагаа зогссон шалтгааныг асуухад тогтсон лам (молда)-гүй, мөн улс төрийн шалтгаантай хэмээн тайлбарлаж байлаа.

Дээрхи сүмүүдийн явуулж буй үйл ажиллагааны чиглэлийг христосын болон буддын шашны хоёр гол сүмийн үйл ажиллагаагаар төлөөлүүлэн авч үзвэл:

Есүс Христийн протестант чуулган нь байгуулагдсанаасаа хойш дараах үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Үүнд:

1. Баруун 5 аймгийн Христэд итгэгчдийн төлөөлөгчдийн Их Хуралдай зохион байгуулагдаж Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Ховдын нийт 170 төлөөлөгчид оролцон, Монгол Улсын ирээдүйн хөгжлийн төлөөх зорилго, зорилт, алсын хараагаа тодорхойлсон.
2. Мөн 5 аймгийн хэмжээнд хүүхдийн цуглааны багш нарын сургалт 2 удаа явуулж, Монгол Улсын ирээдүйн хүүхдийн оюунлаг хөгжилд анхаарч, сургагч багш нарыг бэлтгэж байна.
3. 2008 оны 2 сараас 3 сарын 1-ны хооронд Олон Улсын “Samartitan purse” байгууллага, Монголын Эвангелын эвсэлтэй хамтарч хүүхдэд амьдралд нь өгөгдөх “Хамгийн аугаа бэлэг”- ийг Цаст-Алтай цогцолбор сургуулийн 2-5 ангийн сурагчид, 11 жилийн 1-р сургуулийн 3 ангийн сурагчдад сургууль дээр нь аймгийн төвийн 6 сүм цуглаанаар 2-14 насны 1171 хүүхдэд бэлэг тараасан.
4. “Шинэ амьдрал” цуглаан нь багуудын нэн ядуу, хүүхдээ цэцэрлэгт явуулах боломжгүй айлын 20 хүүхдийг асран халамжилж, үнэ төлбөргүйгээр хооллон, өдөр өнжүүлэх бүлгийг ажиллуулж байна.
5. Мөн энэ цуглаан нь өрх толгойлсон, өвчтэй, нэн ядуу 15 эмэгтэйд хувцас, гурил будаа, ургамлын тос г.м. хоол хүнсний зүйлээр туслалцаа үзүүлсэн.
6. Төвийн дэргэдэх “Мөнхийн дуудлага” цуглаан нь Бичигт багийн өрх толгойлсон 43 айлын судалгаа гарган үүнээс нэн ядуу 5 айлд Цагаан сарын хэрэгцээт зүйлийг авч өгсөн.
7. “Өгөөмөр хайр” цуглаан нь Хорих ангийн хоригдлуудад ёс суртахууны талаар сард 1 удаа сургалт, оймс, хөвөнтэй, бээлий г.м. эд материалаар хангадаг.
8. Мөн энэ цуглаан нь Баруун бүсийн оношлогоо эмчилгээний төвийн сэтгэц наркологийн төвтэй хамтран олон жил сараар өвчтэй байгаа өвчтнүүдэд гарын дор материалаар нэхэх, оёх г.м. гар урлалын зүйлийг хийхэд дэмжлэг үзүүлдэг.

9. "Авралын зам" цуглаан нь баруун бүсийн төв зах дээр архидан согтуурч, ар гэр орон, ахан дүүсдээ ад үзэгдэн, сэтгэл зүйн хувьд гутарсан хүмүүст 7 хоногийн 3 өдөр нь хоол хийж өгөх, сургалт явуулах, амьдралдаа хөлөө олоход нь тусалж байна.

10. Цаашдаа энэ үйл ажилагааныхаа хүрээг улам тэлж өргөжүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахад анхаарч ажиллаж байна.

Дүгнэж үзэхэд, Есүс Христийн протестант чуулган нь Баруун 5 аймаг (Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Завхан) төдийгүй тэдний ихэнхи сумуудад тогтмол үйл ажиллагаа явуулдаг, зохион байгуулалт болон эдийн засгийн чадавхи сайн, хамрах хүрээ өргөн, шүтэн бишрэгчдийн хамрагдах хүрээ нь нийгмийн өвөрмөц хөдөлгөөнтэй бүлгүүд болох хүүхдүүд, өсвөр, залуу үеийнхэн, нийгмийн эмзэг бүлгийнхэн, тухайн цаг үедээ болон нийгмийнхээ дэглэмд шүүмжлэлтэй хандагсад, заримдаа нийгэмд гадуурхагдсан буюу шоовдорлогдсон хүмүүс байх төдийгүй хичээл, сургалт, тусламжийн хэлбэрээр өөрөөр хэлбэл, тэдний сул талыг түшиглэн өөртөө урвуулан шашиндаа татаж оруулдаг нь харагдаж байна. Санхүүгийн хувьд бүрэн бие даасан буюу олон улсын байгууллага, гадны шашны байгууллагуудаас санхүүждэг нь буддын шашны сүм хийдүүдээс илүү давуу байдлыг бий болгодог. Мөн уламжлалт бус шашин нь нүсэр зохион байгуулалт, сүм хийдийн хатуу дэг жаягийг таашаадаггүй буюу онцгой сахил санваар хатуу сахидаггүйгээрээ онцлогтой. Сүм хийдийн гэхээсээ иргэний, олон нийтийн байгууллага, бүлгийн зохион байгуулалтын шинжтэй, хүмүүст өөрсдөө хүрч үйлчилгээ үзүүлдэг г.м. нийтлэн онцлогуудтай байна. Басхүү заримдаа гажууд соёлыг сурталчлах, амьдралыг шүүмжлэн, түүнээс уйдах үзлийг номлох явдал ч байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

"Түгээмэл амаржуулагч" хийд нь байгуулагдсанаасаа хойш дараах үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Үүнд:

1. Долоо хоног болгон тогтмол ном хурж, сүсэгтэн олны хүссэн айлтгал, гүрэм, заслыг хийж, сар болгоныхоо онцлох өдрүүдэд (шинийн 15, 29 г.м.) бурхан багшийн магтаал, Богд ламын ерөөл, магтаал хурах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.
2. Өөрсдийнхөө хүч нөөц бололцоонд тулгуурлан сүмийнхээ гадна дотно засварыг хийсэн.
3. Гандантэгчилэн хийдийн дэргэдэх Урлахуй ухааны дээд төгссөн мэргэжилтэнтэй хамтран Жигжид, 8 тахилын зургийг бүтээсэн.
4. Лам, санваартан нарынхаа боловсрол мэдлэгийг дээшлүүлэх талаар анхаарч сургалт явуулдаг.
5. Хийдийн дэргэд Монголын буддын шашинт оюутны холбоо байгуулж, 7 хоног бүрийн бямба гаригт шашны сургалт явуулж байна.

Гэтэл манай уламжлалт шашны нийгэмд явуулж буй үйл ажиллагааг нь дээрхитэй харьцуулахад үнэхээр ядмаг байгаа нь энэ хоёр шашны нэг жилийн хугацаанд явуулсан үйл ажиллагааны тайлангаас илт харагдаж байгаа юм. Үүнд: урьдын сүм хийдийн устгагдаж сүйдсэн хоосон буурин дээр ямар нэгэн сүм дуган баригдаж, эргэлч, мөргөлчдийн орж гарах орон газар бий болсон нь бодит байдал мөн боловч зөвхөн сэргээж гэсэн утгандаа дүйнэ. Түүнээс биш шашны үзэл номлолын хийгээд ёс заншил, зан үйлийн талаасаа ямар нэг өөрчлөлт, шинэчлэлтийн төлөв ажиглагдахгүй байна. Заримдаа цаг үеэсээ дэндүү холдсон, хэт бүдүүлэг шинжийн элементүүд сэргээгдэх төлөв ажиглагдаж буй нь шашны нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн эдийн засгийн чадавхи сул дорой, зөвхөн сүсэгтний өргөл барьцаар санхүүждэг, ихэнхдээ олон түмний мухар сүсэгт тулгуурласан, тэдний ядуувтар, зовлонт

эрэлт хэрэгцээнд нийцүүлэхээс хэтрэхгүй байна. Тухайлбал, нас барагсдын хойтоход зориулсан буяны ном, ад зэтгэр шулам муу хорлолыг зайлуулах, мэргэ төлгө үзэх г.м.-н зэрэгцээ сүм хийдийн ном уншуулах тариф нь шууд эдийн засгийн утгаар илэрхийлддэг байх жишээтэй. (Хамгийн их эрэлттэй номны үнэ хямд "Хийморийн сан", эрэлт цөөн ном нь өндөр үнэтэй байх "Алтан гэрэл") Бас номны тариф нь хэт өндөр үнэтэй байгаа нь зовсон олонд буян, тус гэхээсээ илүү ядуу амьдралд нь улам бүр дарамт болж байгааг бид бүхэн олон жишээгээр дурьдаж болно.

Өнөөгийн манай бурханы шашны лам хувраг, санваартны нийгмийн бүтэц нь үндсэндээ залгамж шинж чанараа алдаж цаг үеэсээ хоцрогдох төлөвтэй байна. Энэ нь хоёр том сүмд 19 лам шашин номын үйл хэрэг эрхэлж байгаагийн зэрэгцээ тэд шашны ямар хэргэм цолтой эсэхийг хамба лам нь өөрөө тодорхойлж чадахгүй байгааг бид юу гэж ойлговол зохих бэ? гэтэл орхимж зүүсэн мэргэч, төлөгч лам санваартан гэх хүмүүс өнөөдөр хэд хичнээн байгаа тэдний боловсрол мэдлэгийн түвшин хэр вэ? гэдэг асуулт тавиад хариулт эрвэл сонин үр дүн бидэнд харагдаж магадгүй юм.

Басхүү Буддын шашин нийгэмд үр ашигтгүй гэх төөрөгдөлт үзэл байж болох авч бид өнөөдөр өрнө дахинд дорны соёлын уламжлал, буддын шашны үр нөлөө нэмэгдээд байгааг юу гэж үзвэл зохих бэ? Энэ талаар Роберт Турман "Тэгвээс энэхүү шашин түгэн дэлгэрсэн Түвд, Монгол, Вьетнам, Япон, Солонгос зэрэг улс орнуудын үе үеийн үй олон хүмүүсийг тэнэг гэсэнтэй адил болно" гэж хэлсэн нь тун ч үнэний хувьтай байна. Монголд буддизм нь Бурхны шашин, эрдэм ухааны хувьд хөгжсөн төдийгүй монгол айл гэр, хүн бүрийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, уламжлалт зан заншил болон хувирсан нь нэн их" хэмээжээ. (2.)

Гэхдээ миний бие уламжлалт шашин номын үйл хэрэг сэргээгдэж, басхүү их үйл ажил хийж байгааг бүр мөсөн үгүйсгэж байгаа хэрэг бус, харин өнөөдөр Ховд аймагт бодит байдал үнэхээр ямар байгааг л авч үзсэн юм. Энэ бүхэн нь манай уламжлалт буддын шашин шинэчлэгдэх зайлшгүй шаардлага байгааг гэрчилж буй хэрэг бөгөөд миний бие дараах арга замууд байж болох юм хэмээн үзэж байна. Үүнд:

1. "Монгол хүн монголоороо байж, монгол эх орондоо аз жаргалтай амьдрах" нэг эх үндэс нь хүн бүр өөрийн орны түүх, соёл, уламжлалаа дээдэлж түүнийгээ амьдралынхаа утга учир болох хувьд нь буддын шашны зан үйл, соён гэгээрүүлэх үйл хэрэгтэй уялдуулан ойлгож байх.
2. Хувраг лам нарын сонорт хүргэхэд өнгөрсөнд малчид тариачид лам нартаа хандив өргөл өгөөд, бурхны шавь нар нь сүм хийддээ гэгээрэн бясалгаж, тэдний өргөл барьцаар амьдраад байж болдог байсан бол, "өнөөдөр үйлчлэгч биш үйлчлүүлэгч хаан болсон"-ыг ойлгох нь чухал байна. Өөрөөр хэлбэл, орчин үеийн нийгэмд лам хуврагуудын үүрэг хариуцлага их болсон бөгөөд шашныг түгээн дэлгэрүүлэх, таниулан мэдүүлэх талаар хичээл зүтгэлээ нэмэгдүүлэх шаардлагатай.
3. Шашныг ард түмний мухар сүсэгт суурилж бус, орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтуудад уялдуулан хөгжүүлэх хэрэгтэй байна.

Эцэст нь дүгнэхэд:

1. Монгол Улсын "Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар тухайн Нийслэл, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид шашны байгууллагад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгодог аж. Анх 1994 оноос ийнхүү

зөвшөөрөл олгож эхэлсэн юм байна. Аймгийн ИТХ-ын дэргэд шашин сүм хийдийн асуудлыг хариуцсан ажлын хэсэг ажиллаж, ажлын хэсгийн бүрэлдэхвэнд ИТХ-ын төлөөлөгч, Хууль Зүйн Хэлтэс, Тагнуулын ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын алба зэрэг байгууллагуудаас төлөөлөлтэй байх ёстой ажээ. Төр сүм хийдийн харилцааны тухай хуульд нийцүүлэн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс тухайн нутаг дэвсгэрт шинээр шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам батлан тvvний дагуу 13 нэр төрлийн материал бүрдүүлэн авч шашны ажлын хэсэг тухайн зөвшөөрөл хvссэн болон хугацаа сунгуулах шашны байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь vзэж танилцан ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэнээр Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд оруулан асуудлыг шийдвэрлvvлдэг байна. Хэдийгээр ингэж хууль журмын дагуу зөвшөөрөл олгодогч огт зөвшөөрөлгvй үйл ажиллагаа явуулж байгаа христийн зарим сүм байдагт анхаарч нэгдсэн шалгалт явуулж бүртгэлжүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих шаардлагатай байна..

2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудыг авч үзэн, шалгалт хийж, тэдний үйл ажиллагаанд төр захиргааны байгууллага, хууль зүйн хяналтыг сайжруулах шаардлага байна.
3. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд заасан "Буддын шашны зонхилох байр суурийг хvндэтгэн vзнэ" гэдэг заалтыг мөрдлөг болгож байгаа боловч тогтмол үйл ажиллагаа явуулдаг, шинээр зөвшөөрөл авахаар хvсэлт гаргадаг байгууллагын ихэнх нь христийн шашны байгууллага байгаад анхаарах цаг болжээ.
4. Шашины байгууллагаар дамжин улс төрийн ашиг сонирхол бүхий өрсөлдөөн бий болох талтай. Энэ нь хүн амын сүсэгтэй ба шүтлэггүй хүмүүсийн хооронд болон өөр өөр шүтлэгтнүүдийн хоорондын харилцаанд зохих хэмжээгээр нөлөөлнө. Гэтэл төрийг ямар ч халдлагаас хамгаалах нэг гол дархлаа нь шашин байдаг бөгөөд суут Чингис хаан эзлэн түрэмгийлсэн ард иргэдийнхээ шашин суртахуунд их л хүндэтгэлтэй хандаж байсан үүний тод жишээ юм. Бид өнөөдөр төрийн дархлааны тухай ярихдаа шашины асуудлыг орхигдуулж болохгүй асуудал болох хувд нь анхаарах хэрэгтэй байна.

РЕЗЮМЕ

Выводы: В ранних Хобдского аймака занята религиозный деятельностью 7 буддийских монастырей (6 желтой религий, 1 красной), 1 исламский и 3 христианских.

По охвату суеверных традиционная буддийская и исламская религий занимают большинство населения, христианская-чуть меньш. Однако в дальнейшем круг охватаверующих христианской религией будет расширяться из-за того, что у них экономический потенциал. Среди христианских течений превеларует протестантизм или "американизированные", течения, распротраненные из Америка в Азиатских и Восточных странах, оттуда проникиме в Монголию.

НОМ ЗҮЙ

1. XIII Далай ламын “Хүн төрсөн цагаасаа эхлэн үхэн үхтлээ суралцаж байдаг” хэмээх айлтгалаас (Номын хүрдэн клуб, Оллоо mn, 2005-4-11)
2. Л. Чулуунбаатар “Монголчууд яагаад Бурханы шашинд орох болов” хүүрнэл (Olooo.mn,)
3. Монгол улсын “Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах хууль”
Цэдэндамба С. Монгол улс дах шашины нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе).
УБ.,2003.